

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН  
ЗАХИРАМЖИЙН 2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН БИЕЛЭЛТ**

2021 оны 12 дугаар сарын 30

Багануур дүүрэг

№	Ирсэн огноо	Батлагдсан огноо	Дугаар	Биелэлт
1	2021.06.18	2021.06.16	A/477	<p>Засгийн газрын 2021 оны 118 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны A/477 дугаар захирамжийн хүрээнд халдвар хамгааллын дэглэмийг баримтлан байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулж дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлж, ажлын байранд хүний гар хүрэх газрыг 2 цаг тутамд ариутгаж, өдөр бүр 3-4 удаа агаар сэлгэлт хийж, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээ хийх ажлыг зохион байгуулж байна.</li> <li>- Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулан хэрэгжилтэнд шууд хяналт тавьж байна.</li> <li>- Ажилтан албан хаагчдад айл хэсэхгүй, зочин урихгүй, гэр-ажил маршрутаар зорчих чиглэл өгч байна.</li> <li>- ЭМЯ-наас бэлтгэсэн коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмж, сэрэмжлүүлэг, зурагт хуудсыг байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд түгээж байна.</li> </ul> <p>Цар тахалтай холбогдон гарсан бусад шийдвэрүүд, үүрэг даалгаврын хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- НОК-ын 2021.11.24-ний өдрийн 723 дугаартай албан бичгээр өгсөн “Коронавируст халдварын эсрэг дархлаа сэргээх нэмэлт тунгаар вакцинжуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх төлөвлөгөө”-ний 1.4, 1.5 дахь заалтын хэрэгжилтийг ханган ажилласан тайланг 12 дугаар сарын 01-ний өдөр 178 дугаартай албан бичгээр НОК-ын Шуурхай штабт хүргүүлсэн.</li> </ul>
2	2021.11.29	2021.10.22	A/828	<ul style="list-style-type: none"> <li>- Захирамжийг албан хаагчдад танилцуулж, 4 дэх заалтын дагуу Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээж байгаа мэдээг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 189 дугаартай албан</li> </ul>

				бичгээр НЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.
--	--	--	--	---

ХЯНАСАН:  
"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛТ ТЕХНОЛОГИЙН ПАРК"  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э. ЭНХЗАЯА